



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, 13/1, Утас: 26-63-09, Факс: 32-99-33
E-mail: info@cd.gov.mn, http://www.cd.gov.mn/

2013.02.07 № 01/625.

танай _____-ны № _____-т

Үүргээр хангах тухай

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын орон сууцны журам"-ыг харьяа хорих анги, шийдвэр гүйцэтгэх алба, салбар нэгжийн нийт бие бүрэлдэхүүнээр хэлэлцүүлж, ирүүлсэн саналыг үндэслэн "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд баримтлах журам"-ын төслийг шинэчлэн боловсруулсныг ШШГЕГ-ын даргын 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/35 дугаар тушаалаар батлан хүргүүлж байна. Иймд уг журмыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг даалгаж байна. Үүнд:

1. Тус журам батлагдсантай холбогдуулан нийт албан хаагчдын орон сууцны өргөдлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт нэгтгэн бүртгэж байсныг өөрчлөн, харьяа хорих анги, алба, нэгжүүд дээр журамд заасны дагуу бүртгэж байхаар тогтон, орон сууц хүсэгчдийн өргөдлийг холбогдох судалгаа, мэдээллийн хамт хавсралтаар хүргүүлэв. Цаашид орон сууц хүссэн албан хаагчийн өргөдлийг ерөнхий газарт ирүүлэхгүй байх талаар арга хэмжээ авч ажиллах.

2. Ерөнхий газраас харьяа анги, алба, салбар нэгжийн албан хаагчдад олгох орон сууцны тоог хүргүүлж байгаа тул нийт бие бүрэлдэхүүний хурлаар нээлттэй, ил тод хэлэлцэн журамд заасан шалгуур, үзүүлэлтийг бүрэн хангасан, орон сууцны нэн чухал хэрэгцээ, шаардлагатай албан хаагчаа тодруулж, хурлын тэмдэглэл, шийдвэр, амьдарч байгаа орон байрны нөхцөл, лавлагаа, холбогдох бусад материалын хамт 2013 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор Захиргааны удирдлагын газарт ирүүлэх. Хорих анги, алба, нэгжид хуваарилагдсан байрыг дарга нарт олгохгүй бөгөөд тэдний орон сууц хүссэн өргөдлийг ШШГЕГ-ын даргын зөвлөлийн хуралдаанаар тусад нь хэлэлцэн шийдвэрлэх болно.

3. Орон сууцны 1 метр квадрат талбайн үнийг 600 ам доллараар тогтоож байгаа тул Санхүү, аж ахуйн газартай гэрээ байгуулан байрны үнийн урьдчилгаанд 50 хувийн төлбөрийг 2013 оны 03 дугаар сарын 08-ны өдрийн дотор Хас банкны 5000480407 дансанд байршуулах, үлдсэн төлбөрийн 30 хувийг 2013 оны 05 дугаар сарын 01-ний дотор, үлдэгдэл 20 хувийн төлбөрийг 2013 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор

НШГА

ГХОРИХ АНГИ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
АЛБА, САЛБАР НЭГЖИЙН ДАРГА НАРТ

тус дансанд байршуулах, тухайн албан хаагч олгосон байрыг 5 жилийн дотор худалдан борлуулах, бусдад шилжүүлэх эрхгүй байх, байрны хуваарь авсан албан хаагч холбогдох мэдээллийг Санхүү, аж ахуйн газрын даргатай биечлэн уулзаж авах талаар тус тус тайлбарлан ойлгуулсан байх.

4. Хорих анги, алба, нэгжээс ирүүлсэн холбогдох баримт материалыг нягтлан шалгасны үндсэн дээр тухайн албан хаагчид орон сууц олгох асуудлыг ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тушаалаар шийдвэрлэх тул журам болон энэхүү үүргийг зөрчиж албан хаагчид байр олгох санал ирүүлсэн нэгжийн даргад холбогдон гарах хохиролыг нөхөн төлүүлэх, сахилгын шийтгэл ногдуулахыг мэдэгдье.

5. Миний энэ үүргийг нийт бие бүрэлдэхүүндээ уншиж танилцуул.

Жич: Танай байгууллагад 5 тоо / орон сууц хуваарилав.

Орон сууцны өргөдөл гаргагчдын холбогдох материалыг хавсарган хүргүүлэв.
Хавсралт 4 хуудастай.

ДАРГА, ХУРАНДАА  Д.ЯАМДОРЖ